



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

“Өрхийн эмийн сан” хөтөлбөр батлах
тухай

УИХ-ын 1999 оны 46-р тогтоолоор батлагдсан “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах, анхан шатны тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор
ТУШААХ НЬ:


1. Монголын уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэх “Өрхийн эмийн сан” хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, хөтөлбөрийн хүрээнд 2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д. Гончигсүрэн/-т, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар /Ш. Энхбат/-т тус тус даалгасугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж байхыг Санхүү хөрөнгө оруулалтын газар /Н. Түмэндэмбэрэл/-т, холбогдох үйл ажиллагааг санхүүжүүлж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар /Ш. Энхбат/-т үүрэг болгосугай.



САЙД

С. ЛАМБАА

080078



Эрүүл мэндийн сайдын 2012 оны
25-р тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ДЭЛГЭРҮҮЛЭХ
“ӨРХИЙН ЭМИЙН САН” ХӨТӨЛБӨР**

Нэг. Үндэслэл

1990 оноос сэргээгдэн хөгжиж эхэлсэн Монголын уламжлалт анагаах ухааны эмнэлгийн тусламжийг зөвхөн Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн иргэдэд үзүүлж, хөдөө орон нутаг сум, багийн түвшинд уг эмнэлгийн тусламжийг авах боломжгүй байлаа. Иймд уламжлалт анагаах ухааны эмнэлгийн тусламж үйлчилгээг жигд, хүртээмжтэй үзүүлэх, бүх талаар дэмжин хөгжүүлэх зорилгоор “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ыг УИХ-ын 1999 оны 46-р тогтоолоор батлан хэрэгжүүлж эхэлснээс хойш арав гаруй жил болж байна. Уламжлалт анагаах ухааны салбарынхан 2009 онд МУАУ-ны анхдугаар чуулган зохион байгуулж, төрийн бодлогын хэрэгжилтэнд үнэлэлт өгч, уг бодлогын хэрэгжилт, УАУ-ны хөгжлийн өнөөгийн байдал, цаашид шийдвэрлэх тулгамдсан асуудлыг хэлэлцэж, төр засаг, мэргэжлийн байгууллагуудын баримтлах бодлого, чиглэл, хэрэгжүүлэх арга замуудыг оновчтой сонгон, хүн амд УАУ-ны талаар бодитой мэдээлэл өгөх зорилгоор “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан мөрдүүлж байна. Уг хөтөлбөрийн гуравдугаар зорилтод өрх, сумын эмнэлгүүдэд УАУ-ны эмч ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх, өрх, сум, багийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд уламжлалт анагаахын тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх аргуудыг ашиглах, “УАУ-ыг дэлгэрүүлэх төсөл”-д хөдөөгийн малчин өрхийг тодорхой үе шаттайгаар хамруулах боломжийг судлах, хүн амд уламжлалт эрүүл аж төрөх ёс заншлыг дэлгэрүүлэх, хэвшүүлэх ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн юм. Эдгээр ажлуудыг хэрэгжүүлэхэд 2004 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар Монголын УАУ-ыг дэлгэрүүлэх төслийг Япон улсын Ниппон сангийн санхүүгийн тусламжтайгаар Вансэмбэрүү-Монгол” ТББ-ын хэрэгжүүлж, жилд 600-700 сая төгрөг буюу нийт дүнгээр 3795000 доллар зарцуулан Монгол улсын 7 аймгийн 35 сум, өрхийн эмнэлэг, 20000 өрхийг хамруулан Монгол Улсын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх үйлсэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсаар ирлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2011 онд Японд хийсэн албан ёсны айлчлалынхаа үед Ниппон сангийн ерөнхийлөгч Ноён Сасакаватай уулзахдаа Ниппон сангаас 2004 оноос Монгол улсын хөдөөгийн малчин өрхийн дунд хэрэгжүүлсэн “Монголын уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэх-Өрхийн эмийн сан” төслийн ач холбогдлыг өндрөөр үнэлж цаашид Монгол улсын Засгийн газар хөдөөгийн нийт малчин өрхийг үе шаттайгаар хамруулан үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээ амласан билээ. Энэ амлалтын ёсоор 2011 оны 12-р сарын 31-нд Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яам Эрүүл мэндийн тухай хуулийн 4.2.1, 16.7 дугаар заалт, УИХ-ын 46 дугаар тогтоолоор батлагдсан “УАУ-г хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2011 оны 272 тоот тушаал гаран хэрэгжүүлж эхлээд байна. Уг тушаалд Ниппон сангийн санхүүжилтээр “Вансэмбэрүү-Монгол” ТББ-ын хэрэгжүүлж байсан Уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэх “Өрхийн эмийн сан” төслийг хүлээн авч 2012 оноос төсвийн хөрөнгөөр үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, төслийн “Удирдах болон орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны журам”, “Удирдах болон орон нутгийн салбар зөвлөлийн

бүрэлдэхүүнийг"-ийг баталсан байна. Төслийн үйл ажиллагаа нь "Өрхийн эмийн сан", сургалт, явуулыг эмнэлгийн үйлчилгээ, хяналт үнэлгээ, шинжилгээ гэсэн дөрвөн чиглэлээр хэрэгждэг бөгөөд цаашид эдгээр үйл ажиллагааг таслахгүйгээр өргөтгөн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Төсөлд хамрагдах хүсэлтийг аймаг, сумдын захиргааны болон эрүүл мэндийн байгууллага, ард иргэдээс ЭМЯ болон Ниппон сангийн төсөл хэрэгжүүлж байгаа Вансэмбэрүү-Монгол ТББ-т тавьсаар байна.

Хоёр. Зорилго, зорилтууд, баримтлах зарчим, хэрэгжүүлэх хугацаа

Зорилго

УИХ-ын 1999 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан "Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг сайжруулна.

Зорилтууд

1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд УАУ-ны аргуудыг хэрэглэх
2. УАУ-ны эмийн үйлдвэрлэлийг дэмжих, технологийг боловсронгуй болгох, эмийн чанарын хяналтыг сайжруулах
3. Эрүүл мэндийн анхан шатанд тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмч, мэргэжилтнийг УАУ-ны мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах, тусламжийн чанарыг сайжруулах
4. УАУ-ны өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт явуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх
5. УАУ-ны анхан шатны тусламж, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэхэд гадаад орноос авах тусламж, дэмжлэгийг нэмэгдүүлэх

Баримтлах зарчмууд

Энэхүү хөтөлбөр нь дараахи үндсэн зарчимд тулгуурлана:

1. Тэгш, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй байх
2. Эрэлт хэрэгцээнд нийцсэн байх
3. Гэр бүл, олон нийтийн тэгш оролцоог хангах
4. Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
5. УАУ-ны эрүүл, амьдрах, өвчнөөс сэргийлэх аргад тулгуурлах

Хугацаа: 2012-2015

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

Зорилт 1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд УАУ-ны аргуудыг хэрэглэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Өрх, сум, багийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд уламжлалт анагаахын өргөн хэрэглэгддэг 12 эмийн тусламж үйлчилгээ, бариа засал, таван заслын аргуудыг хэрэглэх

- 119
2. “Өрхийн эмийн сан” хэрэглэж буй аймгуудын тайлан мэдээг эрүүл мэндийн улсын нэгдсэн сүлжээнд оруулах
 3. Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд УАУ-ны эмч ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх
 4. “УАУ-ыг дэлгэрүүлэх төсөл”-д орон нутгийн өрх, сумын иргэд, малчдыг тодорхой үе шаттайгаар хамруулах

Хүлээгдэж буй үр дүн

УАУ-ны анхан шатны тусламж, үйлчилгээнд хамрагдах хүний тоо нэмэгдэж, хүн амын уламжлалт эрүүл аж төрөх ёс, заншлын талаарх мэдлэг дээшилж, зан үйлийн зөв хандлага тогтоно.

Зорилт 2. УАУ-ны эмийн үйлдвэрлэлийг дэмжих, технологийг боловсронгуй болгох, эмийн чанарын хяналтыг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Уламжлалт эмийн үйлдвэрийн чанарын хяналтын тогтолцоог (GMP) бий болгох
2. Зонхилон тохиолддог өвчинд хэрэглэх уламжлалт эмийн технологийг боловсронгуй болгох, шинэчлэх
3. Сонгон авсан уламжлалт эмүүдийг эмнэл зүйн судалгаанд оруулж, нотолгоожуулах
4. Монгол орны эмийн ургамал, амьтны болон эрдсийн гаралтай эмчилгээний чанартай түүхий эдийн тархац, нөөцийг сэргээх, хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлэх

Хүлээгдэж буй үр дүн

УАУ-ны эмийн үйлдвэрлэл өргөжиж, технологи нь боловсронгуй болох, нотолгоонд тулгуурласан уламжлалт эмийн тоо нэмэгдэх

Зорилт 3. Эрүүл мэндийн анхан шатанд тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмч, мэргэжилтнийг УАУ-ны мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах, тусламжийн чанарыг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Өрх, сум, багийн эмч нарыг УАУ-ны чиглэлээр мэргэжил олгох, дээшлүүлэх, мэдээллийн технологийг өргөнөөр ашиглах, сургалтанд тодорхой үе шаттайгаар хамруулах
2. Сургалтыг нийслэл хот болон орон нутаг өрх, сум, багийн түвшинд зохион байгуулах
3. Гадаадын улс орнуудад эмч мэргэжилтэн сургах, солилцох, туршлага судлах, давтан сургах ажлыг өргөтгөх

Хүлээгдэж буй үр дүн

УАУ-ны аргуудыг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд хэрэглэх мэдлэг, чадвартай хүний нөөц бий болж, эмнэлгийн тусламжийн чанар сайжирна.

Зорилт 4. УАУ-ны эрүүл аж төрөх ёсны талаар мэдээлэл, сурталчилгаа сургалт явуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Монгол улсын эрүүл мэндийн салбарын эрдэм шинжилгээг 2008-2015 он хүртэл хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд орсон УАУ-ны тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд хийгдэх судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх

2. Төсөлд хамрагдсан сум, багийн эмнэлгийн эмч, сувилагч, ажилтанд уламжлалт анагаах ухааны суурь мэдлэг олгох
3. Төсөлд хамрагдсан өрх, сумын хүн ам, сургуулийн сурагчдад “Өрхийн эмийн сан”-гийн эмийн хэрэглээ болон Монголчуудын эрүүл амьдрах уламжлалт ухааны талаар явуулын сургалт зохион байгуулах
4. Өрхийн эмийн сангийн төслийн үйл ажиллагааны хэрэгжилт ба сумдын тайлан мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ тогтмол хийх

Хүлээгдэж буй үр дүн

УАУ-ны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёсыг шинжлэх ухааны арга, аргачлалаар судлан нотолгоонд суурилсан онол, практик болгон өргөжүүлэх, хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, хандлага дээшилнэ.

Зорилт 5. УАУ-ны анхан шатны тусламж, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэхэд гадаад орноос авах тусламж, дэмжлэгийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. УАУ-ны салбарт хэрэгжүүлж буй олон улсын байгууллага, гадаад орнуудын төслийн хэмжээг нэмэгдүүлэх
2. Япон Улсын Ниппон сантай уламжлалт анагаах ухааны салбарт хамтран ажиллах үйл ажиллагаагаа өргөжүүлэх

Хүлээгдэж буй үр дүн:

Уламжлалт анагаах ухааны салбарын гадаад хамтын ажиллагаа нэмэгдэж улмаар мэдээлэл солилцох, эмчилгээ, үйлчилгээний шинэ арга, технологи нэвтэрч хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Дөрөв. Хяналт шинжилгээ, үнэлгээ

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд дунд хугацааны болон төгсгөлийн үнэлгээг хийнэ. Үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан, холбогдох байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
23 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ДЭЛГЭРҮҮЛЭХ
“ӨРХИЙН ЭМИЙН САН” ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа				Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Шаардагдах төсөв /төг/ 1 жилд
		2012	2013	2014	2015				
1	Удирдах зөвлөлийн хурлыг жилд 4-5 удаа зохион байгуулах	+	+	+	+	ЭМЯ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Батлагдсан шийдвэрийн тоо	0.5 сая
2	Орон нутгийн удирдах зөвлөлийн сургалт (жилд 1 удаа)	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Хамрагдсан хүний тоо	12 сая
3	“Өрхийн эмийн сан”-гийн уламжлалт эмийг сонгох, худалдан авах зорилгоор Тендерийн комисс жилд 1 удаа хуралдах	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ		Сонгосон уламжлалт эмийн тоо	0,5 сая
4	Тендерээр шалгарсан “Өрхийн эмийн сан”-гийн уламжлалт эмийн багцыг жилд 1 удаа худалдан авах, хүргэж өгөх	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Худалдан авсан уламжлалт эмийн тоо	33 сая
5	Тухайн улиралд зонхилон тохиолдох өвчлөлөөс сэргийлэх зорилгоор тодорхой тооны эмийг орон нутагт урьдчилан хуваарилах, эмийн хэрэглээнээс хамаарч эмийн нэмэлт захиалга хийх	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Эмийн тоо	10 сая

6	Хөтөлбөрт шинээр хамрагдсан иргэдэд зориулж 12 уламжлалт эмийн хэрэглээний тухай танилцуулга хэвлүүлж орон нутагт явуулах	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмб эрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Хэвлэсэн уламжлалт эмийн танилцуулгын тоо	2,5 сая
7	Тендэрт шалгарсан уламжлалт эмийн үйлдвэрийн үйл ажиллагаа, явцтай танилцах	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ		Үйл ажиллагаатай нь танилцсан эмийн үйлдвэрийн тоо	-
8	"Өрхийн эмийн сан"-гийн гарын авлага хэвлүүлэх	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ		Хэвлэсэн гарын авлагын тоо	15 сая
9	Эмч нарт зориулсан гарын авлага бичиж хэвлүүлэх	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ			5 сая
10	Өрхийн эмийн сан"-гийн хайрцгийг захиалж авах	+	+	+	+	+	+	+	Вансэмбэрүү-Монгол ТББ	ЗГХА-ЭМГ	Хайрцагны тоо	25 сая /2012 онд Вансэмбэрүү-Монгол ТББ хариуцна/
11	Орон нутгаас ирүүлсэн хугацаа дууссан эмийг устгалд оруулах	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	МХЕГ, Орон нутгийн удирдах зөвлөл	Устгалд оруулсан эмийн тоо	0,5 сая
12	Нийслэл хотод хөтөлбөрт хамрагдсан сумын эмч, багийн эмч нарын нэгдсэн сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Сургалтанд хамрагдсан хүний тоо	40 сая
12	Шинээр хамрагдсан сум, багийн эмнэлгийн эмч, сувилагч, ажилтан хүн ам, сургуулийн сурагчдад "Өрхийн эмийн сан"-гийн эмийг ямар өвчний үед хэрхэн хэрэглэх, эрүүл амьдрах ухааны талаар явуулын сургалт зохион байгуулах	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Сургалтанд хамрагдсан хүний тоо	10 сая

13	Жилд нэг удаа хөтөлбөр хэрэгжүүлэгч шилдэг 3 сумыг сонгон шалгаруулах, ажиллагаараа манлайлсан 10 шилдэг эмч, бага эмчийг Японд Улсад 7 хоногийн сургалтанд хамруулах	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмб эрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Шалгарсан хүний тоо	15 сая
14	Жил бүр хөтөлбөр хэрэгжиж байгаа 3-5 суманд жилд нэг удаа явуулын эмнэлгийн баг илгээж, уламжлалт эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмб эрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Үзлэгт хамрагдсан хүний тоо	10 сая
15	Хөтөлбөр хэрэгжиж байгаа аймаг сумдын үйл ажиллагаа, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	МХЕГ, Орон нутгийн удирдах зөвлөл	Хамрагдсан өрх, сумын тоо	5 сая
16	Улирал тутам хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээ авах	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмб эрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Авсан тайлангийн тоо	0,5 сая
17	Эмийн төлбөрийн тайлан гаргах маягт хэвлүүлэх, тараах, санхүүгийн тайлан гаргах	+	+	+	+	+	+	+	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Гаргасан тайлангийн тоо	24 сая
18	Эмийн төлбөр хураалтын дүнг танилцуулж, дараа оны үйл ажиллагааны төсвийг боловсруулж батлуулах	+	+	+	+	+	+	+	ЭМЯ, Вансэмбэрүү-Монгол ТББ	ЗГХА-ЭМГ, Орон нутгийн удирдах зөвлөл	Төсөв, үйл ажиллагааны тоо	1 сая
19	Радио нэвтрүүлэг, хөтөлбөрийн мэдээ сонин гаргаж хэвлүүлэх	+	+	+	+	+	+	+	Вансэмбэрүү-Монгол ТББ	ЭМЯ, ЗГХА-ЭМГ	Гаргасан нэвтрүүлэг, мэдээний тоо	Вансэмбэрүү-Монгол ТББ-ын зардлаар
	Нийт дүн											209,5 сая

Эрүүл мэндийн сайдын
2012 оны 26 тоот тушаалын гуравдугаар хавсралт

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ДЭЛГЭРҮҮЛЭХ
"ӨРХИЙН ЭМИЙН САН" ТӨСЛИЙН 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх үлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Шалгуур үзүүлэлт	Шаардагдах төсөв /төг/ 1 жилд
1	Удирдах зөвлөлийн хурлыг жилд 4-5 удаа зохион байгуулах	Жилдээ	ЭМЯ	ЗГХА- ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Батлагдсан шийдвэрийн тоо	0.5 сая
2	Орон нутгийн удирдах зөвлөлийн сургалт (жилд 1 удаа)	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Хамрагдсан хүний тоо	12 сая
3	"Өрхийн эмийн сан"-гийн уламжлалт эмийг сонгох, худалдан авах зорилгоор Тендерийн комисс жилд 1 удаа хуралдах	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ		Сонгосон уламжлалт эмийн тоо	0,5 сая
4	Тендерээр шалгарсан "Өрхийн эмийн сан"-гийн уламжлалт эмийн багцыг жилд 1 удаа худалдан авах, хүргэж өгөх	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Худалдан авсан уламжлалт эмийн тоо	33 сая
5	Тухайн улиралд зонхилон тохиолдох өвчлөлөөс сэргийлэх зорилгоор тодорхой тооны эмийг орон нутагт урьдчилан хуваарилах, эмийн хэрэглээнээс хамаарч эмийн нэмэлт захиалга хийх	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Эмийн тоо	10 сая
6	Төсөлд шинээр хамрагдсан иргэдэд зориулж 12 уламжлалт эмийн хэрэглээний тухай танилцуулга хэвлүүлж орон нутагт явуулах	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Хэвлэсэн уламжлалт эмийн танилцуулгын тоо	2,5 сая

7	Тендэрт шалгарсан уламжлалт эмийн үйлдвэрийн үйл ажиллагаа, явцтай танилцах	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ		Үйл ажиллагаатай нь танилцсан эмийн үйлдвэрийн тоо	-
8	"Өрхийн эмийн сан"-гийн гарын авлага хэвлүүлэх	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ		Хэвлэсэн гарын авлагын тоо	15 сая
	Эмч нарт зориулсан гарын авлага бичиж хэвлүүлэх	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ			5 сая
9	"Өрхийн эмийн сан"-гийн хайрцгийг захиалж авах	Жилдээ	Вансэмбэрүү-Монгол ТББ	ЗГХА-ЭМГ	Хайрцагны тоо	25 сая /2012 онд Вансэмбэрүү-Монгол ТББ хариуцна/
10	Орон нутгаас ирүүлсэн хугацаа дууссан эмийг устгалд оруулах	Жилдээ	ЗГ ХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	МХЕГ, Орон нутгийн удирдах зөвлөл	Устгалд оруулсан эмийн тоо	0,5 сая
11	Нийслэл хотод төсөлд хамрагдсан сумын эмч, багийн эмч нарын нэгдсэн сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл,	Сургалтанд хамрагдсан хүний тоо	40 сая
12	Шинээр хамрагдсан сум, багийн эмнэлгийн эмч, сувилагч, ажилтан хүн ам, сургуулийн сурагчдад "Өрхийн эмийн сан"-гийн эмийг ямар өвчний үед хэрхэн хэрэглэх, эрүүл амьдрах ухааны талаар явуулын сургалт зохион байгуулах	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Сургалтанд хамрагдсан хүний тоо	10 сая
13	Жилд нэг удаа шилдэг төсөл хэрэгжүүлэгч 3 сумыг сонгон шалгаруулах, ажиллагаараа манлайлсан 10 шилдэг эмч, бага эмчийг Японд Улсад 7 хоногийн сургалтанд хамруулах	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Шалгарсан хүний тоо	15 сая

14	Жил бүр төсөл хэрэгжиж байгаа 3-5 суманд жилд нэг удаа явуулын эмнэлгийн баг илгээж, уламжлалт эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Үзлэгт хамрагдсан хүний тоо	10 сая
15	Төсөл хэрэгжиж байгаа аймаг сумдын төслийн үйл ажиллагаа, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	МХЕГ, Орон нутгийн удирдах зөвлөл	Хамрагдсан өрх, сумын тоо	5 сая
16	Улирал тутам төслийн хэрэгжилтийн тайлан мэдээ авах	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Авсан тайлангийн тоо	0,5 сая
17	Эмийн төлбөрийн тайлан гаргах маягт хэвлүүлэх, тараах, санхүүгийн тайлан гаргах	Жилдээ	ЗГХА-ЭМГ, Вансэмбэрүү-Монгол ТББ	Орон нутгийн удирдах зөвлөл	Гаргасан тайлангийн тоо	24 сая
18	Эмийн төлбөр хураалтын дүнг танилцуулж, дараа оны үйл ажиллагааны төсвийг боловсруулж батлуулах	Жилдээ	ЭМЯ, Вансэмбэрүү-Монгол ТББ	ЗГХА-ЭМГ, Орон нутгийн удирдах зөвлөл	Төсөв, үйл ажиллагааны тоо	1 сая
19	Радио нэвтрүүлэг, төслийн мэдээ сонин гаргаж хэвлүүлэх	Жилдээ	Вансэмбэрүү-Монгол ТББ	ЭМЯ, ЗГХА-ЭМГ	Гаргасан нэвтрүүлэг, мэдээний тоо	Вансэмбэрүү-Монгол ТББ-ын зардлаар
	Нийт дүн					209,5 сая